

Улаанбаатар хотын музейн сан хөмрөгт хадгалагдаж буй

Ломбардын бичиг үзмэрийн тухай

Abstract: In 1924, a state pawnshop under the municipality of Ulaanbaatar city started operating. However, there is very little information and research about the history and activities of this organization.

Therefore, in the first part of the article, we will briefly mention the history of the state pawnshop organization, and in the main part, the author use the documents of the state pawnshop housed in the Ulaanbaatar City museum as a source, aims to clarify the interest rate and term of pawnshop loan, and what kind of property the people of that time pledged as collateral, whether the pawnshop was a for-profit organization at that time.

Түлхүүр үг: Ломбард, Ломбардын бичиг, Хотын захиргаа, Улаанбаатар хот

Судлагдсан байдал: XX зууны Монгол Улсын эдийн засгийн түүхийн талаарх 1911-1921 оны Монгол Улсын санхүүгийн албаны тухай (Лонжид, Батсайхан., 2000), 1921-1996 оны Монгол Улсын санхүүгийн албаны тухай (Ринчин, Очирпүрэв., 1996), БНМАУ-ын санхүүгийн системийн ерөнхий түүхийн тухай (Түмэн.,2018) судлаачдын бүтээлүүдэд Монгол дахь ломбардын байгууллагын үүсэл, түүхийн талаар огт дурдаагүй байна. Харин ломбард буюу барьцаалан зээлдүүлэх газрын сүүл үеийн эрх зүйн асуудлын тухай бичигдсэн эрдэм шинжилгээний өгүүллэгүүд, дипломын ажлууд цөөнгүй байх бөгөөд эдгээрийн өмнөтгөлд Монгол Улсад 1924 онд ломбард үүссэн тухай товч дурджээ. Үүнээс үзвэл Монгол Улс дахь ломбардын байгууллагын түүх, үйл ажиллагааны талаар тусгайлан судалсан бүтээл огт нийтлэгдээгүй байна. Иймд бид ломбардын байгууллагын түүхийн огт судлагдаагүй байдлыг харгалзан үзэж уг судалгааны эхний хэсэгт ломбардын байгууллага нь дэлхийд хэрхэн үүсэж, Монгол Улсад хэрхэн нэвтэрч, үүсэж хөгжсөн түүхийн талаар дурдаж, өгүүллэгийн үндсэн хэсэгт ломбардын баримт бичгийг судалж судалгааны эргэлтэнд оруулсан болно.

Барьцаалан зээлдүүлэх газрын үүсэл: Хоёр хувь хүн, эсвэл бүлэг хүмүүс шууд эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан сайн дураараа тохиролцон, нэгнийхээ эд хөрөнгийг барьцаалан авч, буцаад хүүтэй мөнгө зээлдэг үйлчилгээг барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ буюу ломбард гэдэг.

Ломбард буюу барьцаалан зээлдүүлэх газар нь эртний түүхтэй санхүүгийн байгууллага юм. Хамгийн эртний барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний байгууллага 3000 жилийн өмнө Эртний хятадад үүссэн бөгөөд тариачдад богино хугацаатай зээл олгодог байв. Мөн эртний Грек, Ромын үед барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ байжээ.²

Дундад зууны үед Италийн Ломбарди мужаас гаралтай мөнгө хүүлэгчид эхлээд Францад, дараа нь Европоор нэг таран бусдын эд зүйлсийг барьцаалан

¹ Улаанбаатар хотын музейн эрдэм шинжилгээний ажилтан

² <https://www.history.co.uk/shows/pawn-stars/articles/pawning-history>